



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын  
нийгмийн хамгааллыг дэмжих, эрүүл мэндийн  
урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо,  
шинжилгээнд хамруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4, 18 дугаар зүйлийн 18.2.4, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 340 дүгээр тушаал, 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/537 тоот тушаалын 3 дугаар хавсралт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн эмч, ажилтнуудын нийгмийн хамгааллыг дэмжих, эрүүл мэндийг нь хамгаалах зорилгоор “Эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндэд тогтмол хяналт тавих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн хуудсыг нэгтгэн цахим мэдээллийн сан бүрдүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан дэд захирал (Б.Батзориг), Халдварын сэргийлэлт хяналтын албаны тархвар судлаач (Г.Оюун-Эрдэнэ), Захирлын ажлын албаны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (Б.Энхцацрал), Захиргаа, хүний нөөцийн албаны мэргэжилтэн (Т.Номинтуяа) нарт, шинжилгээний хариунд дүгнэлт хийн, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Амбулаторийн тасгийн их эмч, эмнэлгийн ажилтнуудын эмч (Ц.Мөнгөнцэцэг)-д, урьдчилан сэргийлэх ажилд тасаг, албадын ажилтнуудыг бүрэн хамруулахыг нийт тасгийн эрхлэгч, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үзлэг, шинжилгээнд шаардлагатай оношлуур, эм эмнэлгийн хэрэгслээр хангаж ажиллахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Ц.Энхбаяр), Эм зүйн албаны дарга (М.Итгэлт), Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч (Э.Лундиамаа) нарт тус тус даалгасугай.

4. “Эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-ийн тайланг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (Б.Энхцацрал), Халдварын сэргийлэлт хяналтын албаны тархвар судлаач (Г.Оюун-Эрдэнэ), Захиргаа, хүний нөөцийн албаны мэргэжилтэн (Т.Номинтуяа), эмнэлгийн ажилтнуудын эмч (Ц.Мөнгөнцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/111 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
Ерөнхий захирлын 2022 оны 07 сарын 07 ны  
А/107 дугаар тушаалын хавсралт



**Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг,  
оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Батзориг (Эрдэм, шинжилгээ инноваци хариуцсан дэд захирал)

**Нарийн бичиг:**

Б.Энхцацрал (ЗААлбаны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан)

Т.Номинтуяа (Захиргаа, хүний нөөцийн албаны мэргэжилтэн)

Г.Оюун-Эрдэнэ (Халдварын хяналт сэргийлэлтийн албаны тархвар судлаач)

**Гишүүд:**

Ц.Энхбаяр (Санхүү бүртгэлийн албаны дарга)

Э.Лундиамаа (Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч)

М.Итгэлт (Эм зүйн албаны дарга)

Г.Лхагвасүрэн (Дүрс оношилгооны тасгийн эрхлэгч)

Ц.Мөнгөнцэцэг (Амбулаторийн тасгийн их эмч, эмнэлгийн ажилтнуудын эмч)

С.Норжмаа (Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга)

Д.Нацагбадам (ЭМТҮЧАБ Албаны эрсдэл аюулгүй байдлын мэргэжилтэн)

П.Энхболд (Захиргаа, хүний нөөцийн албаны менежер)

Э.Эрдэнэбулган (ЭМТҮЧАБ Албаны мэргэжилтэн)

Э.Чинтогтох (Санхүү бүртгэлийн албаны нягтлан бодогч)

О.Оюун-Эрдэнэ (Санхүү бүртгэлийн албаны эдийн засагч)

Б.Оюунмаа (Мэдээлэл технологийн албаны инженер)

Х.Мөнхзул (Статистик, тандалт судалгааны албаны тархвар судлаач)

Б.Үүрцайх (Эмнэл зүйн зохицуулалтын албаны эдийн засагч)

С.Золжаргал (Сувилахуйн мэргэжлийн албаны арга зүйч)

Б.Ууганцэцэг (Дүрс оношлогооны тасгийн ахлах дүрс оношлогооны ахлах техникч)

Д.Энхбаяр (Нийгмийн эрүүл мэндийн албаны нийгмийн ажилтан)

Нийт тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч нар